Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	103,122.7	16,803.9	(86,318.8)
Эм боох материал	19,130.3	4,003.0	(15,127.3)
Бичиг хэргийн материал	9,117.9	2,320.9	(6,797.0)
Аж ахуйн материал	120,694.1	17,725.6	(102,968.5)
Түлш, шатах тослох материал	1,901.0	0.0	(1,901.0)
Хүнсний материал	350.0	0.0	(350.0)
Бусад хангамжийн материал	1,303.7	0.0	(1,303.7)
Мал амьтад	28,938.3	47,719.2	18,780.9
Дүн	295,997.9	88,572.6	(207,425.3)

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 88,572.6 мянган төгрөг болж өмнөх оноос 207,425.3 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв нь улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой тухайн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой байна.

Хүснэгт 5. Байгууллагын бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	Сургууль	Цэцэрлэг	Соёл	ЭМТ	Дүн
Эхний үлдэгдэл	1,222.9	45,305.2	109,605.1	58,166.2	17,317.1	64,381.4	295,997.9
Нэмэгдсэн	10,605.1	122,782.9	-	-	-	-	133,388.0
Худалдан авсан	10,605.1	93,800.8					104,405.9
Шилжүүлэн авсан	-	-					-
Хандиваар ирсэн		14,237.1					14,237.1
Бусад		14,745.0					14,745.0
Хасагдсан	10,420.2	80,923.2	109,605.1	58,166.2	17,317.0	64,381.4	340,813.3
Худалдсан, зарцуулсан	10,420.2	75,803.8					86,224.0
Шилжүүлсэн							65,936.3
Бүтцийн өөрчлөлтөөр			109,605.1	58,166.2	17,317.0	64,381.4	249,469.8
Бусад		5,119.4					5,119.4
Эцсийн үлдэгдэл	1,407.8	87,164.8	-	-	-	-	88,572.6

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 133,388.0 мянган төгрөгийн бараа материалын 104,405.9 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, ОНХС-аас 28,982.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 340,813.3 мянган төгрөгийн 249,469.8 мянган төгрөг буюу 73.2 хувь нь шилжүүлсэн бүтцийн өөрчлөлттэй холбоотой байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,547,717.3 мянга, эцсийн үлдэгдэл 3,313,521.0 мянган төгрөг болж, 3,234,196.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	6,474,875.3	3,282,471.0	-3,192,404.3	99.1
Барилга байгууламж, орон сууц	4,886,899.8	2,235,720.1	-2,651,179.7	68.11
Тээврийн хэрэгсэл	256,114.8	224,827.8	-31,287.0	6.85
Машин тоног төхөөрөмж	685,336.7	278,590.6	-406,746.1	8.49

Тавилга эд хогшил	318,822.8	109,995.5	-29,728.3	3.35
Номын фонд	26,376.0	1,254.5	-208,827.3	0.04
Бусад үндсэн хөрөнгө	301,325.2	432,082.5	130,757.3	13.16
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	72,842.0	31,050.0	-41,792.0	0.9
Программ хангамж	4,600.00	2,950.00	-1,650.00	9.50
Бусад биет бус хөрөнгө	68,242.00	28,100.00	-40142.00	90.50
НИЙТ ДҮН	6,547,717.3	3,313,521.0	3,234,196.3	100.00

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 23,452.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 1,503,503.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагуудаас шилжүүлэн авч, АИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/29 дүгээр тогтоолоор 26,466.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 4,461,685.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

Тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд улсын төсвийн байгууллага болсонтой холбоотой бүтцийн өөрчлөлтөөр 4,461,685.4 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Хүснэгт 7. Байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	ИТХ	ЗДТГ	Сургууль	Цэцэрлэг	Соёл	ЭМТ	Дүн
Эхний үлдэгдэл	15,846.6	1,921,185.1	1,619,845.3	965,789.0	1,323,099.3	701,951.8	6,547,717.2
Нэмэгдсэн	11,330.0	1,515,626.3					1,526,956.3
Худалдан авсан	5,920.0	17,532.9					23,452.9
Шилжүүлэн авсан							
Бусад	5,410.0	1,498,093.4	-	-	-	-	1,503,503.4
Хасагдсан	446.5	26,020.3	1,619,845.3	965,789.0	1,323,099.3	701,951.8	4,637,152.4
Акталсан	446.5	36,020.3					26,466.8
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр			1,619,845.3	965,789.0	1,323,099.3	701,951.8	4,461,685.4
Эцсийн үлдэгдэл	13,638.4	2,601,157.5	-	-	-	-	2,614,795.9

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 93,247.0 мянган төгрөг байсныг тайлант онд бүрэн барагдуулсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллагад төлөх өглөг	Бараа үйлчилгээний зардлын өглөг
1	ЗДТГ	282.5	0.0	0.0	0.0	0.0
2	ЭМТ	92,964.5	0.0	0.0	0.0	0.0
	ДҮН	93,247.0	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,852,532.3 мянга, эцсийн үлдэгдэл 235,921.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,616,610.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	1,852,532.3	235,921.6	(1,616,610.7)	6.6

Хуримтлагдсан үр дүн	3,782,502.2	3,320,889.3	(461,612.9)	92.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	593,823.2	16,799.5	(577,023.7)	0.5
Дүн	6,228,857.7	3,573,610.4	(2,655,247.3)	100.0

Эх сурвалж: "Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан"

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,616,610.7 мянган төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвийн байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр тухайн тайлант нэгтгэгдээгүйтэй холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Гурванбулаг сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн хуралдааны 6/02 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 229,000.0 мянга, татварын бус орлогыг 6,000.0 мянга, нийт 235,000.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант хугацаанд тодотгол хийгдэж 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 8/01 дугаар тогтоолоор татварын орлогыг бууруулж 226,995.5 мянга, татварын бус орлогыг 6,000.0 мянга, нийт 232,995.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 10. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	226,995.5	507,287.8	-280,292.3	223.5
ЦХТА орлого /суутган/	100,000.0	119,349.7	19,349.7	119.3
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	800.0	250.1	-549.9	31.3
Газрын төлбөр	13,200.0	5,499.8	-7,700.2	41.7
ИОТХ	15,000.0	13,217.2	-1,782.8	88.1
Галт зэвсгийн албан татвар	3,000.0	1,170.0	-1,830.0	39.0
Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0	1,350.8	-149.2	90.1
Хадгаламжийн хүүгийн орлого	47,000.0	31,977.6	-15,022.4	68.0
Малын тоо толгойн албан татвар	32,995.5	10,416.3	-22,579.2	31.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10,000.0	6,687.4	-3,312.6	66.9
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	3,000.0	1,980.0	-1,020.0	66.0
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	500.0	0.0	-500.0	0.0
Бусад татвар	0.0	0.2	0.2	
2.Татварын бус орлого	6,000.0	7,780.8	1,780.8	129.7
2.1.Хүү торгуулийн орлого	6,000.0	7,780.8	1,780.8	129.7
Нийт дүн	232,995.5	515,068.6	282,073.1	221.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 221.1 хувь букуу 282,073.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 19,349.7 мянга, хүү, торгуулийн орлогыг 1,780.8 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин үл хөдлөх хөрөнгийн албан татвар 549.9 мянга, газрын төлбөр 7,700.2 мянга, ИОТХ 1,782.8 мянга, галт зэвсгийн албан татвар 1,830.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 149.2 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 15,022.4 мянга, малын тоо толгойн албан татвар 22,579.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3,312.6 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 1,020.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр

500.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байгаа нь иргэдийн хадгаламжийн хүү буурсан, малчид орлогогүй болсон, мөн тус сум нь эхний 5 сард татварын байцаагчгүй байсантай холбоотойгоор орлогын төлөвлөгөө тасарсан гэх тайлбарыг Татварын байцаагч өгсөн болно.

Сумын ИТХ-ын 2022.06.15-ны өдрийн хуралдааны 8/01 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн гүйцэтгэлээр 343.7 мянган төгрөгийн орлогыг оруулж үүргээ биелүүлээгүй байна.

Дээрх тогтоолоор сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 61,600.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 43,531.6 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөө 18,068.4 мянган төгрөг тасарч, 70.6 хувиар биелэлттэй байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт албадан гүйцэтгүүлэх 2 зээлдэгчийн зээл төлөх дараалал болоогүйтэй холбоотой байна.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,353,770.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 996,718.6 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 794,185.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 202,532.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

Хүснэгт 11. Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөрөөр

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Гурванбулаг сумын Засаг дарга	1,353,770.8	996,718.6	357,052.2	
2	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	96,892.2	79,413.6	17,478.6	284.7
3	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	90,087.7	78,349.2	11,738.5	93.4
4	80802 Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	700.0	650.0	50.0	100.0
5	80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	6,104.5	414.4	5,690.1	91.3
8	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	561,624.7	490,784.7	70,840.0	633.4
9	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	301,700.0	297,054.4	4,645.6	98.6
10	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	86,821.9	73,218.2	13,603.7	97.4
11	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	11,150.0	4,220.0	6,930.0	100.0
12	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	67,878.7	58,060.2	9,818.5	95.6
13	80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	22,774.1	22,773.43	0.7	100.0
14	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	45,950.0	10,171.5	35,778.5	22.1
14	82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	10,000.0	9,952.1	47.9	100.0
15	82310 Гамшгаас сэргийлэх	15,350.0	15,334.9	15.1	41.8
16	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	327,189.7	202,533.0	124,656.7	175.0
17	80904 Нийгмийн зориулалттай барилга	72,770.5	68,686.1	4,084.4	91.0
18	83401 Итгэлцүүрээр олгох	151,413.5	90,200.1	61,213.4	67.9
19	83402 Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	12,684.2	8,000.0	4,684.2	0.0
20	83403 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	11,986.8	6,000.0	5,986.8	50.1
21	83405 Малын тоо толгойн албан татвар	39,995.5	0.00	39,995.5	16.1
22	83406 Бусад	38,339.2	29,646.8	8,692.4	0.0
22	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	28,084.0	26,867.6	1,216.4	97.9
23	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	28,084.0	26,867.6	1,216.4	97.9
24	71702 Соёл урлаг	45,909.7	44,104.8	1,804.9	97.0
25	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	45,909.7	44,104.8	1,804.9	97.0
26	71801 Сургуулийн өмнөх боловсрол	46,713.7	40,374.7	6,339.0	94.9
27	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	46,713.7	40,374.7	6,339.0	94.9

28	71802 Ерөнхий боловсрол	132,896.8	112,540.2	20,356.6	94.0
29	80112 ТШЗ-ийн байгууллагын тогтмол зардал	132,896.8	112,540.2	20,356.6	94.0
30	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	114,460.0	100.0	114,360.0	0.0
31	82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	114,460.0	100.0	114,360.0	0.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн гүйцэтгэлийн тайлан

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 4 төсвийн байгууллага, улсын төсвийн сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Гурванбулаг сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн хуралдааны 6/02 дугаар тогтоолоор нийт 1,333,481.4 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт 12. Байгууллагуудын төсвийн төсөл, батлагдсан төсөв /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	64,383.1	89,583.1	25,200.0
Засаг даргын Тамгын газар	316,714.2	475,956.8	159,242.6
Сургууль	173,564.2	198,064.2	24,500.0
Цэцэрлэг	73,754.7	73,754.7	-
Эрүүл мэндийн төв	28,084.0	28,084.1	0.1
Соёлын төв	36,693.4	43,693.0	6,999.6
Сум хөгжүүлэх сан		114,460.0	
Орон нутгийн хөгжлийн сан		309,885.1	
Нийт дүн	693,193.6	1,333,481.4	

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, сумын ИТХХ-ын тогтоол

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.17-ны өдрийн хуралдааны 6/02 дугаар тогтоолоор анх баталсан 1,333,481.4 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.15-ны өдрийн 8/01 дугаар тогтоолоор төсвийг 13,289.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,346,770.8 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Нийт зардлын 232,995.5 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 214,423.7 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 496,244.6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 61,600.0 мянган төгрөгийг СХС-ийн эргэн төлөлтийн орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 214,876.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 72,770.5 мянган төгрөгийг ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс, 52,860.0 мянган төгрөгийг СХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, ОНХС-ийн шилжүүлгийг 1,179.3 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг 18,068.4 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлж, оны эцэст зардлын хэмнэлтээс 117,919.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 13. Байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОН-ын төсөвт төвлөрүүлсэн
Засаг даргын Тамгын газар	561,624.7	477,344.1	84,280.6	85.0	83,624.2

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	96,892.2	79,413.6	17,478.6	82.0	17,478.5
Ерөнхий боловсролын сургууль	132,896.8	112,540.2	20,356.6	84.7	7,456.8
Цэцэрлэг	46,713.7	40,374.6	6,339.1	86.4	6,339.0
Эрүүл мэндийн төв	28,084.0	26,867.6	1,216.4	95.7	1,216.4
Соёлын төв	45,909.7	44,104.8	1,804.9	96.1	1,804.8
Орон нутгийн хөгжлийн сан	320,189.7	202,533.0	117,656.7	63.3	-
Сум хөгжүүлэх сан	114,460.0	100.0	114,360.0	0.1	-
Нийт дүн	1,346,770.8	983,277.9	363,492.9	73.0	117,919.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Жинст сумын байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 983,277.9 мянган төгрөг буюу 73.0 хувьтай байгаа нь Сум хөгжүүлэх сангаас 114,460.0 мянган төгрөгийн хоршоо хөгжүүлэх зээл олгохоор төлөвлөсөн ч олгоогүй, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 35,778.5 мянга, ОНХС-аас 65,000.0 мянган төгрөгийн иргэний танхим байгуулах, өвч тэжээлийн фонд он дамжсан, 59,656.7 мянган төгрөгийн эрчим хүчний шугамын өргөтгөл хийх ажил Дэлхийн банкны санхүүжилтээр 2023 онд хийгдэхээр болсноос шалтгаалж хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 9,198.7 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 23,667.4 мянган төгрөгийн орлого олж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 9,545.5 мянга, хөрөнгийн зардалд 5,000.0 мянган төгрөг нийт 14,545.5 мянган төгрөгийг зарцуулж 18,320.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлага, төвлөрүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	31,566.1	1,300.0	32,866.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,898.7	1,300.0	9,198.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,667.4	0	23,667.4
НИЙТ ЗАРЛАГА	31,566.1	1,300.0	32,866.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	8,440.6	1,104.9	9,545.5
Багаж, техник хэрэгсэл	5,000.0	0	5,000.0
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	18,125.6	195.0	18,320.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Татварын байцаагч малын тоо толгойн албан татварыг 2022 онд 27,914.4 мянган төгрөгөөр ногдуулж, өмнөх оны татварын авлага 5,081.1 төгрөгийг нэмж тооцож сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 8/01 дугаар тогтоолоор малын тоо толгойн албан татварыг 32,995.5 мянган төгрөгөөр баталсан, гүйцэтгэлээр 10,416.3 төгрөгийн орлого төвлөрч 22,579.2 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Тайлант онд Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилт, 54 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт

1,346,770.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 983,227.9 мянган төгрөгийг зарцуулж, хэрэгжилтийг 84.0 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 232,995.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 515,068.6 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 221.1 хувь буюу 282,073.1 мянган төгрөгөөр давж биелсэн боловч 10 нэр төрлийн орлого төлөвлөгөөнөөс тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Гурванбулаг сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт №15. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл					
	Хамрагдвал зохиж	Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс				
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан			Зөрчилг үй	Хязгаар лалтай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
ЗДТГ	1	1			1						
ИТХурал	1	1			1						
ОНХС	1	1			1						
СХС	1	1			1						
НИЙТ ДҮН	4	4			4	0	0	0			0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 20,930.0 мянган төгрөгийн зөрчил, 3,728.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 3,259.3 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 13,942.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Залруулга		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн зөрчил										
ИТХурал	4	4,536.6			1	762.9	2	3,728.7	1	45.0
ЗДТГ	8	16,393.4			4	2,496.4	-	-	4	13,897.0
СХС										
СТА зөрчлийн дүн	12	20,930.0	0	0	5	3,259.3	2	3,728.7	5	13,942.0
СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал										
ЗДТГ	1	-							1	-
Нийцлийн аудитын дүн	1	-	-	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	13	20,930.0	0	0	5	3,259.3	2	3,728.7	5	13,942.0

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 20,930.0 мянган төгрөгийн 12 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 1 зөрчил тус тус илэрсэн байна.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн

/мянган төгрөгөөр/

Огноо	Аудитын нэр:	Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:		
2022			БНА-2023/1/СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Гурванбулаг сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
A	1	2	3	Албан тушаал	Овог нэр
Харьяа төсвийн байгууллагуудын дүн		20,930.0			
Засаг даргын тамгын газар		16,393.4			
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
1	Засаг даргын нөөц хөрөнгөөс сайн малчны шагналд 6 ширхэг нэг бүр нь 176,000 төгрөгийн үнэтэй нийт 1,056,000 төгрөгийн үнэ бүхий мөнгөн аяга, сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд 1,220,000 төгрөгийн цахилгаан халаагуур, олон нийтийн цагдаа Б.Сүмбэрзүлд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн урамшуулалд 2,520,000 төгрөг, төсөвт 6 байгууллагын оны шилдэг ажилтны шагналд 1,500,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.	6,296.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
2	Сумын төв доторх үйлчилгээнд 54,200 төгрөг, рашааны тахилгад 119,950 төгрөг, нийт 174,150 төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	174.1	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
3	Засаг даргын нөөц хөрөнгөөс шатрын аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд Г.Эрдэнэ-Очирт 120,000 төгрөг, морин хуурын улсын уралдаанд оролцох зардалд Б.Түвшин-Очирт 450,000 төгрөг, аймгийн аварга шалгаруулах болейволын тэмцээний зардалд 210,000 төгрөг, жүдо бөхийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээний зардалд 800,000 төгрөг, ардын урлагийн их наадамд оролцох зардалд 200,000 төгрөг, шагайн харвааны тэмцээний зардалд 271,000 төгрөг, цэрэг татлагын барилдааны шагналд 250,000 төгрөг, соёлын төвийн албан хаагчдын чуулга уулзалтын шагналын зардалд 1,000,000 төгрөг, нийт 3,301,000 төгрөгийг зарцуулсан	3,301.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
4	Засаг даргын нөөц хөрөнгөөс ЗДТГ-ын даргын цэргийн хээрийн хувцас авахад 333,000 төгрөг, дуучин Б.Мөнх-Ирээдүйд бие даасан тоглолт хийхэд 1,000,000 төгрөг зарцуулсан байна.	1,333.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
5	Нярав П.Цэцэгдэмбэрэлийн охин Д.Шүрэнцэцэгийн сургалтын төлбөрт 1,000,000 төгрөгийг зарцуулсан байна.	1,000.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
6	Засаг даргын нөөц хөрөнгөөс 5 иргэнд эмчилгээний зардалд 500,000-1,000,000 төгрөг нийт 3,300,000 төгрөгийг олгосон байна.	3,300.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
7	Албан хаагчдыг рашаан сувилалд амруулах зардалд шатахууны зардлаас 489.260 төгрөгийг зарцуулсан байна.	489.3	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
8	ОУХМ Б.Ойдовчимэдийн нэрэмжит жүдо бөхийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас 500,000 төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна.	500.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал					
9	Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 41,490,298 төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрдалай
Дүн					
Иргэдийн төлөөлөгчдийн хурал		4,536.6			
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл		4,536.6			
1	Байгууллагын даргын тушаалаар 4 ажилтанд тус бүр 150.0 мянга, нийт 450.0 мянган төгрөгийн түлшний	45.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Алтанцэцэг, Б.Дэлгэрдалай

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	хөнгөлөлт олгоходоо хуулийн дагуу ХХОАТ суутгаагүй байна.				
2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.2."Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томиллолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчиж 762.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.	762.9	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	С.Алтанцэцэг, Б.Дэлгэрдалай
3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2-д заасны дагуу горим сорил хэрэгжүүлэхэд өмнөх оноос бичиг хэргийн зардлыг 58.4 хувь, тээвэр шатахууны зардлыг 36.3 хувь, нийт 1728.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.	1,728.7	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Алтанцэцэг, Б.Дэлгэрдалай
4	2011 онд үүссэн насжилт өндөртэй 2000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	2,000.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Алтанцэцэг, Б.Дэлгэрдалай

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.03.10-ны өдөр сумын Засаг даргаас 3/31 дугаар албан бичгээр ирүүлсэн, ирүүлсэн албан бичигт Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаж, дараах үр дүн гарсан гэж тайлагнасан байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 203 дугаар тогтоолыг батлагдсантай холбоотой байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарт хэвлэн хүргүүлсэн.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд ЕБС, цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ-ийн тогтмол зардлаас 16,816.9 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын нь сумын төв доторх үйлчилгээний шатахуунд 5,2 мянга, рашааны тахилгын шатахуунд 119.9 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс ЗДТГ-ын даргын цэргийн хээрийн хувцас авахад 333.0 мянга, дуучин Б.Мөнх-Ирээдүйд бие даасан тоглолт хийхэд 1,000.0 мянга, ОУХМ Б.Ойдовчимэдийн нэрэмжит жүдо бөхийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас 500.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд тус тус зарцуулж Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан нь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2022 оны 3 дугаар улиралд хийгдсэн хяналтаар мэдээллийг засаж байршуулсантай холбоотой байна. Цахим хуудсанд 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Хүснэгт 18. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	12	12	10	-	2
2	Хагас жил	3	3	2	1	-
3	Улирал бүр	2	8	8	-	-
4	Сар бүр	5	60	60	-	-
5	Тухай бүр	6	72	65	7	-
	Нийт	28	155	145	8	2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1,230.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 125 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 19. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	1,230.0	4	1,230.0	-	-	100
Нийт	4	1,230.0	4	1,230.0	-	-	100

Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 39,423.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 22,579.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй 16,844.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1. Албан шаардлага

1. Гурванбулаг сумын малын тоо толгойн албан татвараар 32,995.5 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 10,416.3 мянган төгрөг оруулж, татварын орлогын төлөвлөгөөг 22,579,2 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ нь мал тоо, толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно", 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь. Сумын малын тоо толгойн албан татварыг үнэн зөв тодорхойлон төлөвлөж, 2022 оны дутуу татвар, 2023 оны татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлага өгөв.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 221.1 хувь буюу 282,073.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар 549.9 мянга, газрын төлбөр 7,700.2 мянга, ИОТХ 1,782.8 мянга, галт зэвсгийн албан татвар 1,830.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 149.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3,312.6 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 1,020.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 500.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголттой холбоотой.

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд 114,460.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч тайлант онд зээл олгоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг олгож, сангийн үр ашгийн нэмэгдүүлэх.

3. Дотоод, хяналт хариуцлагатай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Гурванбулаг сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 20,930.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 3,728.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 3,259.3 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 13,942.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид Сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийг мөрдөж Засаг дарга өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад тавих хяналт, төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт /мянган төгрөгөөр/

Огноо 2022	Аудитын нэр:	Гурванбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/1/СТА-ТТЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Гурванбулаг сумын Засаг дарга	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
	1	2	3	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
	ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар:				
1	Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 221.1 хувь буюу 282,073.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч үл хөдлөх хөрөнгийн албан татвар 549.9 мянга, газрын төлбөр 7,700.2 мянга, ИОТХ 1,782.8 мянга, галт зэвсгийн албан татвар 1,830.0 мянга, улсын тэмдэгтийн хураамж 149.2 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 3,312.6 мянга, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 1,020.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 500.0 мянга, нийт 16,844.7 мянган төгрөгөөр татварын орлого тасарсан байна.	16,844.7	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тонтохжаргал
2	Хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд 114,460.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч тайлант онд зээл олгоогүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тонтохжаргал
3	Гурванбулаг сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 20,930.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 3,728.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 3,259.3 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 13,942.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна	-	Зөвлөмж өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тонтохжаргал
4	Гурванбулаг сумын малын тоо толгойн албан татвараар 32,995.5 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 10,416.3 мянган төгрөг оруулж, татварын орлогын төлөвлөгөөг 22,579.2 мянган төгрөгөөр биелүүлээгүй байна.	22,579.2	Албан шаардлага өгсөн	Төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тонтохжаргал
	ДҮН	39,423.9			

---оОо---